



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар A/167

Улаанбаатар хот

Түр журам батлах, өөрийн үнэлгээний
систем нэвтрүүлэх тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.8.2, 4.12.14, 9.2 заалт, Ректорын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн багш, ажилтны өөрийн үнэлгээний систем”-ийг хэрэгжүүлэх түр журмыг хавсралтаар баталж, өөрийн үнэлгээний системийг 2016-2017 оны хичээлийн жилээс туршилтын журмаар ШУТИС-ийн хэмжээнд нэвтрүүлж хэрэгжүүлсүгэй.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол эрхэлсэн проректор /Х.Энхжаргал/, Захиргаа, мониторингийн газрын дарга /Л.Пүрэв/, Сургалтын бодлого, чанарын албаны дарга /Д.Ганхуяг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

РЕКТОР

Б.ОЧИРБАТ





Ректорын 2016 оны 11 сарын 07-ны
өдрийн А/167 тоот тушаалын хавсралт

“ШУТИС-ийн багш, ажилтны өөрийн үнэлгээний систем”-ийг

хэрэгжүүлэх түр журам

Нэг. Зорилго

ШУТИС-ийн багш, ажилтны үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулан, биелэлтэнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, сургалт, эрдэм шинжилгээ, нийгэм олон нийтийн ажлын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх.

Багш, ажилтны ажлын үр дүнг хичээлийн жилээр бодитой, шуурхай дүгнэн, ажилтнуудын албан тушаалын ангилал, цалин урамшуулал, шагналын системийг боловсронгуй, үнэн зөв, ил тод болгох.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. “ШУТИС-ийн багш, ажилтны өөрийн үнэлгээний систем” нь Багшийн өөрийн үнэлгээний систем, Ажилтны өөрийн үнэлгээний систем гэсэн үндсэн хоёр дэд системээс тогтоно.

2.2. Багшийн ажлын өөрийн үнэлгээний дэд систем нь А-сургалтын үйл ажиллагаа, Б- эрдэм шинжилгээ, судалгаа, В- хувь хүний хөгжил, сургууль, олон нийтийн үйлчилгээ гэсэн үндсэн 3 хэсгээс тогтох бөгөөд багшийн ажлын үнэлгээгээр авч болох дээд оноо нь 1000 байна.

2.3. Ажилтны өөрийн үнэлгээний дэд систем нь А-ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, Б-удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хийж гүйцэтгэсэн ажил, В-бие дааж санаачлан гүйцэтгэсэн ажил, Г-маннайлал, нийгэм, олон нийтийн ажил, Д-хувь хүний хөгжил гэсэн үндсэн 5 хэсэгтэй бөгөөд ажилтны жилийн ажлын гүйцэтгэлээр авч болох дээд оноо нь 100 байна.

2.4. Багшийн ангилалд салбар, тэнхимиийн эрхлэгч, профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш нар хамаарна.

2.5. Ажилтан гэсэн ангилалд проректор, газар, албадын дарга, захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ажилтан нар хамаарна.

Гурав. Нийтлэг шаардлага, үнэлгээний зарчим

3.1. Багш, ажилтны хичээлийн жилийн ажлын гүйцэтгэл, түүний үнэлгээг баталгаажуулах, үнэлгээтэй холбоотой гарсан асуудлыг нягталж шийдвэрлэх, үнэлгээний үр дүнд дүгнэлт хийж, санал боловсруулах үүрэгтэй ШУТИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан Үнэлгээний комисс ажиллана.

3.2. ШУТИС-ийн багш, ажилтан хичээлийн жилд хийж гүйцэтгэсэн ажлаа өөрөө үнэлж дүгнэхээс гадна түүний ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийгдэнэ.



Ректорын 2016 оны 11 сарын 07-ны
өдрийн А/167 тоот тушаалын хавсралт

Хөндлөнгийн үнэлгээ нь багш, ажилтны шууд удирдлагын болон хамт олны үнэлгээ гэсэн хоёр хэсэгтэй байна.

3.3. Багш, ажилтан нь тухайн хичээлийн жилийн зорилттой уялдуулан ажлын төлөвлөгөөгөө оновчтой төлөвлөж 09 дүгээр сарын 15-ны дотор өөрийн үнэлгээний системд оруулна.

3.4. Харьяа нэгжийн удирдлага багш, ажилтны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөгөө 09 дүгээр сарын 20-ны дотор хянаж баталгаажуулснаар төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийгдэхгүй болно.

3.5. Багш, ажилтан хичээлийн жилийн турш өөрийн гүйцэтгэсэн ажлаа цаг тухайд нь системд оруулж, өөрийн үнэлгээг өгнө. Хичээлийн жилийн төгсгөлд буюу, 06 дугаар сарын 5-нд систем хаагдаж, багш, ажилтны ажлын өөрийн үнэлгээ, гүйцэтгэл гарна.

3.6. Багш, ажилтны хичээлийн жилд гүйцэтгэсэн ажлын өөрийн үнэлгээг харьяа нэгжийн шууд удирдлага 06 дугаар сарын 10-ны дотор хянаж үнэлгээ өгнө. Үүнтэй зэрэгцэн тухайн багш, ажилтны ажлын гүйцэтгэл, өөрийн үнэлгээнд хамт ажиллагсдаас нь санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 5-аас илүүгүй гишүүн хамт олны хөндлөнгийн үнэлгээ өгнө.

Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээний дүн нь харьяа нэгжийн удирдлагын үнэлгээ, хамт олны үнэлгээ хоёрын нийлбэрийн дунджаар тодорхойлогдоно.

3.7. Багшийн ажлын гүйцэтгэлд бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал үнэлгээ өгч болох бөгөөд энэ тохиолдолд хөндлөнгийн үнэлгээний дүн нь харьяа нэгжийн удирдлага, хамт олон, дэд захирлын үнэлгээний дунджаар тодорхойлогдоно.

3.8. Хэрэв багш, ажилтны өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний зөрүү хэлбэлзэл 25%-аас ихгүй байвал өөрийн үнэлгээг бодитой, үнэн зөв гэж үзнэ.

3.9. Багш, ажилтан хичээлийн жилийн ажлын гүйцэтгэл, өөрийн үнэлгээтэй холбоотой асуудлаар эхлээд өөрийн шууд удирдлагад хандана. Хэрэв багш, ажилтны ажлын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний зөрүүтэй холбоотой маргаантай асуудал түүний шууд удирдлагын хэмжээнд шийдэгдэхгүй бол Үнэлгээний комисст хандана.

3.10. Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр хийгдэж болох албан тушаалын зэрэглэлийн өөрчлөлт, шагнал урамшуулал, хариуцлагын асуудлаар гаргасан харьяа нэгжийн удирдлагын саналыг Үнэлгээний комисс хянаж, сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүлнэ.

3.11. Үнэлгээний комисс ШУТИС-ийн нийт багш, ажилтны хичээлийн жилийн ажлын гүйцэтгэл, үнэлгээний ажлын үр дүнд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж сургуулийн захиргаанд танилцуулах үүрэгтэй.